



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 5/26

Бор-өндөр сум

**Н.Бямбасүрэнг гэмтэл согог
судлалын эмчээр томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 48 дугаар зүйлийн 48.1, 50 дугаар зүйлийн 50.1, Засгийн газрын 2019 оны “Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, 2018 оны “Журам батлах тухай” 382 дугаар тогтоолын 6, 7 дугаар хавсралт, 2022 оны “Журамд өөрчлөлт оруулах тухай” 491 дүгээр тогтоол, Нэгдсэн эмнэлгийн даргын 2022 оны “Эмч, ажилчдын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” б/26 тоот тушаал, Эрүүл мэндийн сайдын 2018 оны “Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчдын хоол унааны хөнгөлөлт, нэмэгдэл, урамшлын хэмжээг тогтоох тухай” А/548 тоот тушаал, 2020 оны “Хамтын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах тухай” А/69 дугаар тушаал, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Найдангийн Бямбасүрэнг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Гэмтэл согог судлалын эмчээр томилон ажиллуулсугай.

2. Н.Бямбасүрэнг ТҮЭМ7-1 шатлалаар тогтоон үндсэн цалинг 1.061.389 (нэг сая жаран нэгэн мянга гурван зуун наян ес), хоолны мөнгө өдрийн 3000 (гурван мянга), Орон нутагт ажилласны нэмэгдэл цалингийн 20% 212.278 (хоёр зуун арван хоёр мянга хоёр зуун далан найм), төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 6% 63.683 (жаран гурван мянга зургаан зуун наян гурав), хөдөлмөрийн хэвийн бус нөхцлийн нэмэгдэл цалингийн 10% 106.139 (зуун арван мянга есөн зуун жаран гурав) төгрөгөөр тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Т.Эрдэнэболор)-т зөвшөөрсүгэй.

3. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ёс зүйн хэм хэмжээг мөрдөн ажиллахыг Н.Бямбасүрэнд үүрэг болгосугай.

ДАРГА  А.БАТБААТАР

